



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 1/122

Шивээговь сум

Хэлний бодлогын салбар зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хэлний бодлогын салбар зөвлөл ажиллах журам”-ын 2.4.1, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/155 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хэлний бодлогын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

П.Ганчимэг (сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Д.Сувд-Эрдэнэ (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд:

Э.Төрмандах (Соёлын төвийн дарга)

Л.Цолмон (Ерөнхий боловсролын сургуулийн Сургалтын менежер)

Б.Чулуунцэцэг (Монгол хэл, уран зохиолын багш)

Б.Золжаргал (Монгол хэл, уран зохиолын багш)

О.Ууганцэцэг (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Иргэний танхимын ажилтан)

2. Салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулахыг салбар зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх, нийт төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, байгууллагын нэр хаягийг монгол бичгээр бичиж хэвшихийг аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ